



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 1125

Алтай хот

Барилгын ажлын зөвшөөрөл
олгохоос татгалзах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрмийн 5.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Өргөө засал" ХХК нь газар эзэмших эрх олгогдоогүй, архитектур төлөвлөлтийн даалгавар аваагүй, холбогдох техникийн нөхцөлүүдийг аваагүй, ажлын зураг хийлгэж, магадлал хийгдээгүй байхад барилгын ажлыг эхлүүлсэн, дээрх баримт бичгүүдийг барилга баригдаж дуусах хүртэл хугацааны явцад бүрдүүлсэн, 5 градусаас хүйтэн болсон буюу өвлийн улиралд захиалагчийн хяналтгүйгээр барилгын тухай холбогдох хууль тогтоомж, барилгын норм дүрэм зөрчиж барьсан, шүүхийн шийдвэр гарахад уг барилга баригдан ажлын гүйцэтгэл 95 хувьд хүрсэн байсан нь шүүхийн шийдвэрт дурдсанаар нотлогдож, тус компани нь холбогдох хууль журмыг зөрчин барилгын ажлыг эхлүүлж 95 хувьд хүргэсэн байдал нь татгалзах үндэслэл болж байх тул Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Есөнбулаг сумын Оргил багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа "9 айлын 2 блок" орон сууцны барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг даалгасан 2022 оны 112/ШШ2022/0026 дугаар шийдвэрийн хүрээнд ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР